

ШУУРХАЙ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2019 оны 5 дугаар сарын 6

№ 13

Дархан-Уул аймаг

Аймгийн Засаг даргын Шуурхай хурал 2019 оны 5 дугаар сарын 6-ны өдрийн 08 цаг 00 минутад аймгийн Засаг даргын Тамгын газрын хурлын зааланд хуралдав. Хуралдааныг аймгийн Засаг дарга С.Насанбат удирдаж, хуралд нийт 15 удирдах албан тушаалтнууд оролцохоос 15 оролцож хуралдааны ирц 83.3 хувьтай байв. Гишүүдийн ирцийн бүртгэлийг хавсаргав.

ХУРАЛДААНААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДАЛ:

1.Хэлтэс, алба, сумдын дарга нарын өнгөрсөн 7 хоногийн ажлын тайлан, холбогдох шуурхай мэдээ, мэдээллийг танилцуулах, өмнөх шуурхай хурлаас өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтийн талаарх мэдээ, тайланг танилцуулах.

Хуралд оролцсон хэлтэс, албад, сумдын дарга нар өнгөрсөн 7 хоногт хийсэн ажлын тайланг танилцуулав.

ҮҮРЭГ ДААЛГАВАР:

Мод тарих өдрийг сайн сурталчилж ямар мод, хаана тарих хуваарь боловсруулах, мод тарьж буй аж ахуйн нэгж байгууллагыг сурталчилж таниулах, үлгэр жишээ болгох 2019 оны орон нутгийн төсвийн тодотголыг аймгийн ИТХ-ын хуралдаанаар хэлэлцүүлэхийн өмнө УИХ-ын гишүүдийн саналыг авах

Ой хээрийн түймэр намжих төлөвтэй байна. Эргүүл тойруулын ажлыг хийе. Зулзагат гарсан гал тамхины ишнээс болсон гэсэн дүгнэлт гарсан. Хөгжлийн бодлогын хэлтэс анхаарч ажиллаарай.

Мал бүхий иргэдийг хотоос гаргах ажлыг Дархан сум хариуцаж ажиллахаар болсон. Сүүлийн үед хотын ногоон байгууламж руу адуу их орж байна. Эдийн засгийн аргаар үүнтэй тэмцье. Зөрчлийн тухай хуулийн 7.7.2-оор торгох боломж байгаа. Дархан сум үүнийг ажил болгох

Замын нөхөөсийн ажлыг эхлүүлье. Хуваарь гаргаж ажлаа явуулъя.

Малын удмын сан, ХХААГ хооронд санамж бичиг байгуулж, үйл ажиллагааг нь уяж явуулах. Энэ 7 хоногт төвийн захиралтай уулзалт товлох

ХОХБТХ харъяа агентлагуудынхаа хурлыг хийх Улирлын чанартай үйлдвэрлэлүүд эхэлсэн. Гэр гуанз, зайрмаг гээд эдгээр үйлдвэрлэлүүдэд хяналт тавих

Олон улсын сувилагчдын өдрийг зохион байгуулахад анхаарах

Сүүлийн үед иргэд 10, 20-оороо өрөөнд орж ирээд хэл ам их хийх боллоо. Аймгийн ЗДТГ-т ажиллаж байгаа харуулын удирдлагатай уулзалт хийх, гадаа үүдэнд хязгаарлалт хийдэг болох. Одоо ажиллаж байгаа хамгаалалтын албанд хэлж сургах

Багийн төвийн байрны зээлийн асуудлаар ХОХБТХ, Дархан сум хамтарсан уулзалт хийх

Үнэлгээний хороогоо сайн ажиллуул. Маргаантай асуудлаа дотроо шийдэж байгаад орж ирэх. Тайлбараа бичгээр сайтар боловсруулж байх

Байрны өргөдлүүдээ нэг газраа төвлөрүүлье. Хурлыг ойрын хугацаанд хийж Амарсанаа, Энхтөр нарт хариуг нь өгөх

Төрөх эмнэлгийн нээлтээ 10-ний өдөр хийе.

Хурал 9 цаг 05 минутад дуусав

ТӨРИЙН ЗАХИРГААНЫ УДИРДЛАГЫН ХЭЛТЭС